笔译

90. Том хэмжээний гамшигт өртсөний дараа хүмүүсийн зан байдал ухамсаргүйгээр өөрчлөгдөж, тэр бүү хэл өөрийн зан үйлийн хэв маягийг бүрмөсөн өөрчилж ч болдог. Жишээлбэл, зарим судалгаанаас харахад газар хөдлөлтөд өртсөн хүмүүс газар хөдлөлтөөс хойшхи гурван жилийн хугацаанд илүү хуучинсаг зан чанартай болж, бусад бүлгийн хүмүүстэй харьцуулахад эрсдэлтэй зан үйл хийх магадлал нь бага болдог байна. Энэ нь асар их цочролын нөлөөн дор хүмүүс эрсдэлээс татгалзаж, тогтвортой байдлыг эрэлхийлдэг болохыг харуулж байна.

91. 略

口译

92. Олны хөл хөдөлгөөнөөс зайлсхийхийн тулд залуучуудын дунд "урвуу аялал жуулчлал" аажмаар бий болж, зарим алдартай бус аялал жуулчлалын хотууд хүмүүсийн хараанд өртөх болжээ. Амралтын үеэрх алдартай аялал жуулчлалын газруудын “хүн хүнтэй шахцалдсан” байдлаас залхсанаас болон олон залуус, ялангуяа хотын завгүй амьдралаас зугтахыг хүссэн залуус өөр сонголтыг туршиж эхэлж байна. Тэд чөлөөт цагаа тийм ч алдартай биш амрахад таатай газарт зарцуулж, өвөрмөц, тайван амралтыг эрэлхийлэн, хүмүүс амрах үеэрээ алдартай, хөл хөдөлгөөнтэй газар руу зорихоос эсрэгээр байх болжээ. “Урвуу аялал жуулчлал” нь Хятад залуусын аялал жуулчлалын нэгэн төрлийн шинэ хандлага болоод байна.

93. 略